

ЦАХИУРЫН ХӨНДИЙН СҮҮДЭР

ХҮНИЙ ЭРХИЙН МАГАДЛАН ШИНЖИЛГЭЭНИЙ
ДУТМАГ БАЙДАЛ

ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНЛ



Business & Human Rights
Resource Centre

**ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ НЬ ХҮН БҮРД
ЭРХИЙГ НЬ ЭДЛҮҮЛЭХИЙН ТӨЛӨӨ ХҮМҮҮСИЙН
ХҮНЛЭГ СЭТГЭЛД ТУЛГУУРЛАН КАМПАНИТ
АЖИЛ ӨРНҮҮЛДЭГ 10 САЯ ХҮНИЙГ ЭГНЭЭНДЭЭ
НЭГТГЭСЭН ДЭЛХИЙ ДАЯАРХ ХҮНИЙ ЭРХИЙН
ХАМГААЛАГЧДЫН ХӨДӨЛГӨӨН ЮМ.**

Бид аливаа засгийн газар, улс төрийн үзэл суртал, эдийн засгийн ашиг сонирхол, шашин шүтлэгээс ангид бие даасан, хараат бус бөгөөд гишүүд дэмжигчдийнхээ хандив тусламжаар санхүүждэг.

Хүмүүс эв санааны нэгдэлтэй, хүмүүнлэг энэрэнгүй байснаар илүү сайхан нийгмийг бий болгож, өөрчилж чадна гэдэгт бид итгэдэг.

© Amnesty International 2023

Энэхүү бүтээл нь оюуны өмчийн бүртгэлтэй болно. (зохиогчийн нэрийг дурдана, худалдахгүй, хуулбарлахгүй, олон улсын 4.0 зөвшөөрөл). <https://creativecommons.org/licenses/by-nc-nd/4.0/legalcode>

Дэлгэрэнгүй мэдээллийг манай цахим хуудсаас авна уу.
www.amnesty.mn

2024 онд анх хэвлэгдэв.
Amnesty International Ltd
Ийстон Гудамж 1, Петер Бененсоны Ордон
Лондон хот WC1X 0DW, UK

Индекс: POL 40/7108/2023
Хэл: Англи

**ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНЛ**



**БИЗНЕС БА ХҮНИЙ ЭРХИЙН МЭДЭЭЛЛИЙН ТӨВ НЬ
180 ГАРУЙ УЛСЫН 10,000 ГАРУЙ КОМПАНИЙ
ХҮНИЙ ЭРХЭД НӨЛӨӨЛЖ БҮЙ НӨЛӨӨЛЛИЙГ
БАРИМТЖУУЛАН ШАЛГАЖ, ӨӨРСДИЙН
ЦАХИМ ХУУДСААР ДАМЖУУЛАН 10 ГАРУЙ
ХЭЛ ДЭЭР МЭДЭЭЛДЭГ ОЛОН УЛСЫН ТӨРИЙН БҮС
БАЙГУУЛЛАГА ЮМ.**

Бизнесийн байгууллагууд нь хүний эрхийг хүндэтгэж, зөрчлийг арилгаж, тогтвортой зах зээл болон бизнесийн орчин, хүний эрхийг дээдэлсэн ирээдүйг бий болгоход манлайлан оролцдог, баялгийн тэгш байдлыг хангасан хамтын хөгжил цэцэглэлтийг хүн бүр эдлэх боломжтой дэлхий ертөнцийг бүтээх нь бидний алсын хараа юм.

Бид бизнес эрхлэгчдийг хүний эрхийг хүндэтгэж, дээдэлдэг тэгш нийгмийг бүтээхийн тулд өөрсдийн түнш, холбоотон болон иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажилладаг.

Бид засгийн газар, бизнесийн байгууллагуудын шийдвэр гаргагчдад зөвхөн ашиг дээр суурилсан бизнесийн үйл ажиллагааг хүний эрхийг хүндэтгэсэн эдийн засгийн загвар бүхий болгон өөрчлөхөд шаардлагатай хууль, дүрэм болон хэм хэмжээг батлан гаргахад нь нөлөөлөх баримтуудыг цуглуулан дүн шинжилгээ хийж, ил болгохыг зорин ажилладаг.

Бид хүний эрхийн зөрчилд хариуцлага тооцох зорилгоор ажиллаж буй өөрсдийн түнш, холбоотон, хөдөлгөөнүүдийг дэмжиж ажилладаг.



АГУУЛГА

1. ХУРААНГУЙ
2. АРГА ЗҮЙ
3. ХҮНИЙ ЭРХЭД ЭРСДЭЛ ДАГУУЛЖ БУЙ
ГЕНЕРАТИВ (ҮҮСГЭГЧ) ХИЙМЭЛ ОЮУН УХААН
4. ВЕНЧУР КАПИТАЛ ФИРМ ХҮНИЙ ЭРХИЙН
МАГАДЛАН ШИНЖИЛГЭЭ ХИЙХИЙН АЧ
ХОЛБОГДОЛ
5. ҮР ДҮНГИЙН ХУРААНГУЙ
6. ДҮГНЭЛТ
7. ЗӨВЛӨМЖ
8. ХАВСРАЛТ А: ВЕНЧУР КАПИТАЛЫН
ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС
9. ХАВСРАЛТ Б: ВЕНЧУР КАПИТАЛ ФИРМУҮДЭД
ХАНДСАН ЗАХИДАЛ



ХУРААНГУЙ

2023 онд ChatGPT танилцуулагдаж, зах зээлд гарснаас хойш генератив (үүсгэгч) хиймэл оюун ухаанд (Generative AI) оруулах хөрөнгө оруулалт **асар ихээр** нэмэгдсэн.

2023 оны эхний зургаан сарын дотор үүсгэгч хиймэл оюун ухаанд суурилсан шийдэл, хэрэгслийн санхүүжилт 2022 онтой харьцуулахад **тав дахин** нэмэгдэж, тэр дундаа венчур капитал (VC) фирмүүд тэднийг санхүүжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн.

2032 он гэхэд үүсгэгч хиймэл оюун ухааны зах зээл **200.73 тэрбум ам.долларт** хүрэх төлөвтэй байгаа бөгөөд тус технологийг дараагийн «**зэвсгийн уралдаан**»-ы хөдөлгөгч хүч гэж тодорхойлж байна.

ХУРААНГҮЙ

Генератив (үүсгэгч) хиймэл оюун ухаан гэдэг нь аудио, зураг, текст, тэр ч байтугай компьютерын код зэрэг шинэ контент үүсгэх боломжтой алгоритмын системийг хэлнэ.

Аливаа шинэ технологийн нэгэн адил эдгээр систем нь нийгэмд байгаа өрөөсгөл ойлголт, тэгш бус байдлыг нэмэгдүүлэх, хувийн нууцтай холбоотой эрхүүдийг зөрчиж, буруу ташаа мэдээлэл түгээх зэрэг болзошгүй эрсдэлүүдийг үүсгэж байна. Фрийдом Хаусын мэдээлснээр, үүсгэгч хиймэл оюун ухааныг хамгийн багадаа 16 улсад “буруу мэдээлэл тараах, эсэргүүцэгчдийг гутаан доромжлох, олон нийтийн мэтгэлцээнд нөлөөлөх” зорилгоор ашигласан нь нотлогдсон. 2023 онд Блүүмбэрг үүсгэгч хиймэл оюун ухаан ашиглаж хийгдсэн 5000 гаруй зурагт дүн шинжилгээ хийхэд, өндөр цалинтай ажлын байрыг цайвар арьстай хүмүүсээр илэрхийлдэг болохыг тогтоожээ. Түүнээс гадна, гэрийн үйлчлэгч, кассчин зэрэг бага цалинтай ажлуудаас бусад ажлын байрыг эрэгтэй хүний зургаар дүрслэн харуулсан байна.

Үүсгэгч хиймэл оюун ухааны платформ болох ChatGPT-г бүтээсэн OpenAI-ийн гүйцэтгэх захирал Сэм Алтман хэлэхдээ **“Хэрэв энэ технологи буруу чиглэл рүүгээ явбал, үр дүн нь үнэхээр муу байх болно”** гэжээ. Гэвч тус технологийн үр нөлөө үүнээс ч дор байх боломжтой. Учир нь одоогоор үүсгэгч хиймэл оюун ухаан барагтаа зохицуулалтгүй ашиглагдаж байна.

Үүсгэгч хиймэл оюун ухааны хэрэгслүүд нь олон төрлийн бүтээлч байдал, шинэ арга, бүтээмжийг нэмэгдүүлэх (судалгаа болон орчуулга), олон янз хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст илүү хүртээмжтэй болж байгаа зэрэг олон боломжийг олгож байгаа ч компаниуд эдгээрийг бусдад хохирол учруулахгүйгээр бүрэн хэрэгжүүлэхийн тулд тухайн

технологийг зохион бүтээх, хөгжүүлэх, ашиглахдаа хүний эрхийг дээдэлсэн хандлагыг чухалчилж, хэрэгжүүлэх нь маш чухал юм.

ГЕНЕРАТИВ (ҮҮСГЭГЧ) ХИЙМЭЛ ОЮУН УХААН НЬ АУДИО, ЗУРАГ, ТЕКСТ, ТЭР Ч БАЙТУГАЙ КОМПЬЮТЕРЫН КОД ЗЭРЭГ ШИНЭ КОНТЕНТ БҮТЭЭХ БОЛОМЖТОЙ АЛГОРИТМЫН СИСТЕМИЙГ ХЭЛНЭ.

Эдгээр эрсдэлийг арилгах, бууруулах, бодит хор уршгаас урьдчилан сэргийлэх үүрэг нь дан ганц үүсгэгч хиймэл оюун ухаан дээр суурилсан бүтээгдэхүүн хөгжүүлж буй улс орнууд, компаниудад хамааралтай биш бөгөөд хөрөнгө оруулагчид, тэр дундаа олон тооны үүсгэгч хиймэл оюун ухаанд суурилсан гарааны бизнесийг санхүүжүүлж байгаа венчур капитал (VC) фирмүүдэд бас хамаарна. Үүсгэгч хиймэл оюун ухаан дээр суурилсан хүний эрхийн эдгээр эрсдэлийг тодорхойлох, ойлгох, урьдчилан сэргийлэх, бууруулах нь шийдэх ёстой нэн чухал асуудал юм. Учир нь энэхүү технологи хувьсан өөрчлөгдөх боломжтой технологи юм.

Гэсэн хэдий ч Эмнести Интернэшнл, Бизнес ба Хүний Эрхийн Мэдээллийн Төвөөс хийсэн энэ судалгаанаас харахад тэргүүлэгч Венчур Капитал (VC) фирмүүд нийгэмд хор хөнөөлтэй, зарим тохиолдолд залруулах боломжгүй үр дагаварт хүрч болзошгүй хиймэл оюун ухааны технологийн эрсдэл, бодит хор уршгийг арилгах үүрэг хариуцлагаа, тэр дундаа хүний эрхийн магадлан шинжилгээ хийж чадахгүй байгааг харуулж байна. Үнэн хэрэгтээ хэд хэдэн тэргүүлэгч венчур капитал фирмүүд энэхүү хандлагыг эсэргүүцэж байгаа бөгөөд тэдний

нэг Андреесен Хоровиц венчур капиталыг үүсгэн байгуулагч Марк Андреесен юм. Тэрээр хэлэхдээ: “Бидэнд дайснууд байна... Өнөөгийн нийгэм сүүлийн 60 жилийн турш технологийн болон хүмүүсийн амьдралын эсрэг кампанит ажил өрнүүлж, “нийгмийн хариуцлага”, “оролцогч талуудын капитализм (компани нь зөвхөн өөрийн хувьцаа эзэмшигчид бус бусад бүх оролцогч талуудын ашиг сонирхолыг анхаарах, үүнд үйлчлэх ёстой гэсэн ойлголт)”, “урьдчилан сэргийлэх зарчим”, “итгэлцэл ба аюулгүй байдал”, “техникийн ёс зүй”, “эрсдэлийн менежмент” гэх мэт янз бүрийн **томьёолол дор** нийтийг бүхэлд нь ёс суртахууны доголдолд оруулж байна” гэж мэдэгджээ.

Компани болон хөрөнгө оруулагчид дэлхийн хаана үйл ажиллагаа явуулж байгаагаас үл хамааран өөрийн бүхий л үйл ажиллагааныхаа явцад хүний эрхийг хүндэтгэх үүрэгтэй. Энэ нь НҮБ-ын Бизнес ба Хүний эрхийн удирдах зарчмууд (НҮБ-ын удирдах зарчмууд) зэрэг олон улсын нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээ юм. Энэхүү үүрэг хариуцлагыг биелүүлэхийн тулд компани, хөрөнгө оруулагчид, түүний дотор Венчур Капитал (VC) фирмүүд өөрсдийн бий болгосон эсхүл бий болгож болзошгүй хүний эрхийн зөрчлийг илрүүлэх мөн арилгах шаардлагатай арга хэмжээг авах ёстой. Энэ нь хүний эрхийн магадлан шинжилгээ хийхгүйгээр бодит болох боломжгүй юм.

Үүсгэгч хиймэл оюун ухаанд ихээхэн хөрөнгө оруулалт хийсэн венчур Капитал (VC) фирмүүдийн үйл ажиллагааг үнэлэхийн тулд АНУ-ын Эмнести Интернэшнл болон Бизнес ба Хүний Эрхийн Мэдээллийн Төвөөс үүсгэгч хиймэл оюун ухаанд суурилсан компаниудад хөрөнгө оруулалт хийсэн хамгийн том 10 венчур капитал (VC) -ийн сан болон 2 гарааны бизнес хурдасгуурт хүний эрхийн магадлан шинжилгээ хийж байгаа эсэхийг тодорхойлох зорилгоор асуумж явуулсан.

Судалгаанд хамрагдсан компаниуд нь Инсай Партнерс (Insight Partners), Таягар Глобал Менежмент (Tiger Global Management), Сикуюиа Капитал (Sequoia Capital), Андреесен Хоровиц (Andreessen Horowitz), Лаятспид Венчур Партнерс (Lightspeed Venture Partners), Нью Энтерпрайс Ассосиатес (New Enterprise Associates), Бэссэмер Венчур Партнерс (Bessemer Venture Partners), Женерал Каталист Партнерс (General Catalyst Partners), Фоундерс Фанд (Founders Fund), Технологи Кроссовер Венчурс (Technology Crossover Ventures), Текстарс (Techstars) болон Вая Комбинатор (Y Combinator) болно. Эдгээр бүх компани АНУ-д байрладаг. АНУ-ын Эмнести Интернэшнл болон Бизнес ба Хүний Эрхийн Мэдээллийн Төв нь венчур капитал (VC) -ийн сангууд болон тэдний хөрөнгө оруулагчдын хүний эрхийн магадлан шинжилгээ хийж буй түвшинг тодорхойлохын тулд эхлээд венчур капитал (VC) компаниудын болон хурдасгууруудын нийтэд нээлттэй байршуулсан хүний эрхийн бодлогод судалгаа хийсэн. Дараа нь үүнийг бататгахын тулд эдгээр сангийн ерөнхий зөвлөхүүд эсвэл бусад ахлах албан тушаалтнуудад дэлгэрэнгүй захидал илгээсэн.

Энэхүү судалгааны үр дүнд тэргүүлэгч венчур капитал (VC) фирмүүд болон гарааны бизнесийн хурдасгуурууд үүсгэгч хиймэл оюун ухааны гарааны бизнест хөрөнгө оруулахдаа хүний эрхийн магадлан шинжилгээ хийх үүрэгээ маш хангалтгүй биелүүлж байгаа болох нь батлагдсан. Бид дараах байдлаар гол судалгааны үр дүнг гаргалаа:

12 ФИРМИЙН ЗӨВХӨН 3 НЬ

Хөрөнгө оруулалт оруулахдаа хариуцлагатай технологийг чухалчлан авч үзэх амлалтыг олон нийтэд өгсөн тухай дурдсан.

12 ФИРМИЙН ЗӨВХӨН 1 НЬ

Хүний эрхтэй холбоотой тодорхой амлалт өгсөн

12 ФИРМИЙН ЗӨВХӨН 1 НЬ

Аливаа компанид хөрөнгө оруулах шийдвэр гаргах мөн хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл (LPS) сонгох үедээ хүний эрхийн магадлан шинжилгээг хийдэг гэж хариулсан. Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл (LPS) гэдэг нь венчур капитал (VC) фирмүүдийн хөрөнгө оруулалтын санд санхүүжилт олгодог хөрөнгө оруулагчид юм.

12 ФИРМИЙН ЗӨВХӨН 1 НЬ

Өөрсдийн хөрөнгө оруулсан компаниуддаа хариуцлагатай технологитой холбоотой асуудалд дэмжлэг үзүүлдэг бол 2 нь дэмжлэг үзүүлж, эхлэх шатандаа явж байна.

Тэргүүлэгч венчур капитал (VC) фирмүүд болон хурдасгуур сангууд үүсгэгч хиймэл оюун ухаанд онцгой ач холбогдол өгөн хөрөнгө оруулж байгаа учир НҮБ-ын Удирдах зарчмуудад тусгагдсан хүний эрхтэй холбоотой хүлээсэн үүргээ нэн тэргүүнд авч үзэн, биелүүлэхгүй байх магадлал улам ихэссээр байна.

Ил тод байдал, хүний эрхийн магадлан шинжилгээ, оролцогч талуудтай ялангуяа иргэний нийгмийн байгууллагуудтай үр дүнтэйгээр хамтран ажиллах нь технологи дахь хариуцлагатай хөрөнгө оруулалтыг бий болгоход маш чухал бөгөөд үүний тулд хөрөнгө оруулагчид өөрсдийн үүргийг биелүүлж, хариуцлагыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.



АРГА ЗҮЙ

Венчур капитал (VC) фирмүүдийн хүний эрхэд үзүүлж буй нөлөөллийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, бууруулах зорилгоор хүний эрхийн магадлан шинжилгээ аль хүрээнд хийж буйг судлан тогтоохын тулд АНУ-ын Эмнести Интернэшнл, Бизнес ба Хүний Эрхийн Мэдээллийн Төвөөс дор хаяж 1 үүсгэгч хиймэл оюун ухаанд хөрөнгө оруулсан хамгийн том 10 венчур капитал сан болон 2 гарааны бизнесийн хурдасгуур сангийн бодлогод дүн шинжилгээ хийсэн.

Бид венчур капитал сэтгүүлийн 2022 оны хамгийн том тавин венчур капитал (VC)-ийн жагсаалтыг ашиглан менежментийн хөрөнгө дээр (AUM) нь тулгуурлаж хамгийн том фирмүүдийг тодорхойлж, дараа нь DealRoom-ийн (гарааны бизнес болон венчур капитал (VC)-ийн санхүүжилтийн талаарх мэдээлэл цуглуулдаг компани) өгөгдлийг ашиглан эдгээрээс аль нь генератив (үүсгэгч) хиймэл оюун ухаанд суурилсан компаниудад хөрөнгө оруулалт хийснийг тодорхойлсон.

АРГА ЗҮЙ

Энэхүү аргачлалын хүрээнд хамгийн багадаа нэг генератив (үүсгэгч) хиймэл оюун ухааныг хөгжүүлэхэд хөрөнгө оруулсан 10 венчур капитал (VC) фирмүүдийг тодорхойлсон бөгөөд эдгээр нь: Инсаят Партнерс (Insight Partners), Таягар Глобал Менежмент (Tiger Global Management), Сикуюиа Капитал (Sequoia Capital), Андреесен Хоровиц (Andreessen Horowitz), Лаятспид Венчур Партнерс (Lightspeed Venture Partners), Нью Энтерпрайс Ассоциатес (New Enterprise Associates), Бэссэмер Венчур Партнерс (Bessemer Venture Partners), Женерал Каталист Партнерс (General Catalyst Partners), Фоундерс Фанд (Founders Fund) болон Технологи Кроссовер Венчурс (Technology Crossover Ventures) болно. Энэхүү аргачлалын хүрээнд хамгийн багадаа нэг үүсгэгч хиймэл оюун ухааныг хөгжүүлэхэд хөрөнгө оруулсан 2 гарааны бизнесийн хурдасгуур байгаа бөгөөд эдгээр нь Техстарс (Techstars) болон Вая Комбинатор (Y Combinator) юм. Эдгээр бүх фирм АНУ-д бүртгэлтэй.

Венчур Капитал (VC) сангууд болон тэдгээрийн хөрөнгө оруулагчид хүний эрхийн магадлан шинжилгээ хийдэг эсэхийг тодорхойлохын тулд АНУ-ын Эмнести Интернэшнл, Бизнес ба Хүний Эрхийн Мэдээллийн Төв эхлээд венчур капитал (VC) фирм болон хурдасгуурын хүний эрхийн бодлогод вэбсайт дээр байршуулсан олон нийтэд нээлттэй мэдээлэлд тулгуурлан эхний дүн шинжилгээг хийсэн. Гэвч үр дүнд хүрэхэд хэд хэдэн асуудал тулгарсан. Зарим сан хайлт хийх боломжгүй цахим хуудастай байсан; зарим сан өөрсдийн хийж гүйцэтгэсэн хүний эрхийн магадлан шинжилгээг олон нийтэд зориулан өөрсдийн цахим хуудсанд оруулаагүй байх боломжтой. Зарим сан “Хөрөнгө оруулалтын

бодлого”, “Эрсдэлийн удирдлагын бодлого” эсвэл “ТУЗ-ийн журам ба практик” зэрэг баримт бичгүүдэд хүний эрхийн магадлан шинжилгээний зарим хэсгийг тусгасан байх боломжтой.

АНУ-ын Эмнести Интернэшнл, Бизнес ба Хүний Эрхийн Мэдээллийн Төвөөс 12 венчур капитал (VC) фирм болон хурдасгууруудад захидал илгээсэн боловч аль нь ч буцааж хариу ирүүлээгүй. Тиймээс, бид 2023 оны 11-р сарын 9-нд энэхүү товч тайлангийн үр дүнг тоймлон, нэмэлт тайлбар, тодруулга авахыг хүссэн захидал илгээсэн. Гэвч, фирмүүдийн аль нь ч эдгээр захидалд хариу ирүүлээгүй.

Тиймээс бидний үнэлгээ зөвхөн нийтэд нээлттэй баримт бичигт үндэслэн хийгдсэн болно. Хавсралт А-д венчур капитал (VC)-ийн үнэлгээний хуудсыг хавсаргасан бол венчур капитал (VC)-д илгээсэн захидлын жишээг Хавсралт В-д хавсаргасан.

АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХИЙН ТУЛД АНУ-ЫН ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ БОЛОН БИЗНЕС БА ХҮНИЙ ЭРХИЙН МЭДЭЭЛЛИЙН ТӨВ ЭДГЭЭР 10 ВЕНЧУР КАПИТАЛ (VC) ФИРМ БОЛОН 2 ГАРААНЫ БИЗНЕСИЙН ХУРДАСГУУРЫН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨХҮҮД БОЛОН БУСАД АХЛАХ АЛБАН ТУШААЛТНУУДАД 2023 ОНЫ 5-Р САРЫН 23-Н ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙГ АГУУЛСАН ДЭЛГЭРЭНГҮЙ ЗАХИДАЛ ИЛГЭЭСЭН.

ГЭВЧ АЛЬ Ч ФИРМ ХАРИУ ӨГӨӨГҮЙ.



ГЕНЕРАТИВ (ҮҮСГЭГЧ) ХИЙМЭЛ ОЮУН УХААНЫ УЛМААС УЧИРЧ БҮЙ ХҮНИЙ ЭРХТЭЙ ХОЛБООТОЙ ЭРСДЭЛ

Томоохон технологийн компаний захирал, хэрэглэгчдийн бүлэг, сэтгүүлч, хувь хүний нүүцлалтай холбоотой эрх хамгаалагчид, засгийн газрын агентлагууд, тэр ч байтугай зарим хөрөнгө оруулагчид үүсгэгч хиймэл оюун ухаан хүний эрхийн зөрчил үүсгэж байгаа тухай дурдаж ирсэн.

Эдгээр технологийг нийгмийн сайн сайхны төлөө ашиглахад удирдлага болох шаардлагатай зохицуулалтууд байхгүй байхад тус бүтээгдэхүүн нь зах зээлд нэвтэрсэн учир хувийн хэвшил илүү өндөр хяналт, нарийн зохицуулалт, мөн урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах шаардлагатай байна.

Үүсгэгч хиймэл оюун ухааны давуу талыг ашиглахын тулд уг технологийн хувь хүн болон нийгэмд учруулж болох хамгийн ноцтой эрсдэлүүдийг НҮБ-ын удирдах зарчмуудын хүрээнд зайлшгүй ялгаж, салгаж, шийдвэрлэх шаардлагатай.

ГЕНЕРАТИВ (ҮҮСГЭГЧ) ХИЙМЭЛ ОЮУН УХААНЫН УЛМААС УЧИРЧ БУЙ ХҮНИЙ ЭРХТЭЙ ХОЛБООТОЙ ЭРСДЭЛ

Доор дурдсанчлан, үүсгэгч хиймэл оюун ухаан нь бие махбодийн, сэтгэл зүйн болон нэр хүндэд хохирол учруулж, нийгэм дэх тодорхой бүлэг эсхүл хүнийг гутаан доромжлох үйлдэл, эдийн засгийн тогтворгүй байдал цаашлаад хувь хүний болон олон нийтийн ялгаварлан гадуурхалтыг улам хурцатгах боломжтой. Ялангуяа, **зөрчилдөөн ихтэй бүсэд, хилийн заагт** эсвэл **эмзэг бүлгийн хүмүүстэй** холбоотойгоор үүсгэгч хиймэл оюун ухааныг ашиглахад өндөр эрсдэлтэй байх боломжтой.

Шударга ёс, ил тод байдал болон хариуцлагатай байдал хангагдаагүй үед компаниуд, **хэвлэл мэдээллийнхэн** эсвэл **төрийн байгууллагууд** энэхүү технологийг яаран хэрэглэх нь асар их сөрөг үр дагаварт хүргэж болзошгүй юм. Эдгээр бүтээгдэхүүнийг хэрхэн хөгжүүлж мөн ашиглагдаж байгаа талаар мэдээлэл ил тод бус; хөрөнгө оруулагчид эсвэл компаниудад байгаль орчин, хүний эрхийн магадлан шинжилгээ хийх заавал биелэгдэх шинжтэй хууль ёсны шаардлага байхгүй; хиймэл оюун ухаан хөгжүүлэгчид болон гарааны бизнес эрхлэгчид өөрсдийн үйл ажиллагааг бүрэн тайлбарлаж, бүтээгдэхүүний үр дагаврыг бүрэн тодорхойлох чадваргүй; мөн үүсгэгч хиймэл оюун ухаан хүний эрхэд шууд болон шууд бусаар хохирол учруулсан тохиолдолд хариуцлага тооцох хууль эрх зүйн орчин бүс нутгийн, үндэсний болон олон улсын түвшинд одоог хүртэл байхгүй байгаа нь дээрх асуудлуудыг улам гүнзгийрүүлж байна.

Зарим хөрөнгө оруулагч, компаниуд үүсгэгч хиймэл оюун ухааныг буруугаар ашиглах боломжит магадлалыг ил тод хүлээн зөвшөөрч байхад, **зарим нь** тус салбарыг “өндөр эрсдэлт бүлэг”-т хамаатуулахгүй байх зорилгоор **төрийн байгууллагын шийдвэр гаргагчдыг** нууцаар **лоббидож** байна.

Аль хэдийн үүссэн болон үүсэж болзошгүй асуудлуудаас харахад хөрөнгө оруулагчид хиймэл оюун ухаан хөгжүүлж буй компани эсвэл түүн дээр суурилсан бүтээгдэхүүнийг санхүүжүүлэхдээ хүний эрхийн дараах томоохон эрсдэлүүдийг харгалзан үзэх шаардлагатай. Тиймээс дараах жагсаалтад хамгийн их тулгарч болзошгүй хүний эрхийн зөрчлүүдийг багтаахыг зорилоо.

ХҮНИЙ ХУВИЙН МЭДЭЭЛЛИЙГ ХАМГААЛАХТАЙ ХОЛБООТОЙ ЗӨРЧИЛ

Шаардлагатай өгөгдлийг цуглуулах, хамгаалах, мэдээллийн эх сурвалжийг ил болгохтой холбоотой зохицуулалт байхгүйгээс үүдэж, компаниуд үүсгэгч хиймэл оюун ухааны загварыг хөгжүүлэх, сайжруулах зорилгоор маш их хэмжээний өгөгдлийг (жишээлбэл, хувийн мэдээлэл агуулсан) цуглуулж, ашиглахыг эрмэлздэг. Мэдээллийн болон **кибер аюулгүй байдлын эрсдэлээс** гадна, компаниуд хиймэл оюун ухааныг хөгжүүлэх явцдаа гуравдагч этгээдээс **хүний хувийн мэдээллийг** авах замаар хүний хувийн мэдээллээ **хамгаалах эрхийн зөрчлийг** үүсгэж байна.

ГЕЙ ХҮМҮҮСИЙГ ЭСРЭГ ХҮЙСТНЭЭ СОНИРХДОГ БОЛГОХЫГ ЗӨВЛӨСӨН ЭМЧИЛГЭЭГ ГҮҮГЛИЙН БАРД САНАЛ БОЛГОЖ, ХОЛОКОСТЫГ ХЭЗЭЭ Ч БОЛООГҮЙ ГЭЖ ҮГҮЙСГЭСЭН ТОХИОЛДОЛ ГАРСАН.



ЭПИК-ийн судлаачдын дурьдаж буйгаар компаниуд хүмүүсийн хувийн мэдээллийг ашиглахдаа зөвшилцдөггүй бөгөөд ихэнх хүн өөрийн хувийн мэдээллээ ашиглуулж байгаа талаар ямар ч мэдээлэлгүй байдаг. 2022 онд **Калифорнид амьдардаг нэгэн уран бүтээлч** өөрийн эмчилгээний үед авахуулсан зургаа хиймэл оюун ухаанд суурилж зургийн модель хөгжүүлэгч “LAION-5B” зургийн багцаас олсон. Хүмүүсийн хувийн мэдээлэл задрах эрсдэл өндөр, мөн уг мэдээллийг устгах боломж хомс байгаа тохиолдолд урт хугацаандаа хүмүүс цахим орчинд өөртэйгээ холбоотой аливаа мэдээллийг оруулах нь **эрс багасна.**

ХҮМҮҮСИЙН ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ ЗАДРАХ ЭРСДЭЛ ӨНДӨР. УГ МЭДЭЭЛЛИЙГ УСТГАХ БОЛОМЖ ХОМС БАЙГАА ТОХИОЛДОЛД УРТ ХУГАЦААНДАА ХҮМҮҮС ЦАХИМ ОРЧИНД ӨӨРТЭЙГЭЭ ХОЛБООТОЙ АЛИВАА МЭДЭЭЛЛИЙГ ОРУУЛАХ НЬ ЭРС БАГАСАХ НӨХЦЛИЙГ БҮРДҮҮЛЖ БАЙНА.

АЛГОРИТМД ТОГТСОН НЭГ ТАЛЫГ БАРИМТАЛСАН БОЛОН ХЭВШМЭЛ ОЙЛГОЛТ БҮХИЙ МЭДЭЭЛЛИЙГ ХАДГАЛЖ ҮЛДЭХ НЬ

Үүсгэгч хиймэл оюун ухааны системүүд нь сургалтын өгөгдлөөс үүдэлтэйгээр бий болсон **нэг талыг баримталсан мөн хэвшмэл ойлголт бүхий** мэдээллүүдийг хуулбарлан түгээх боломжтой. Нэг талыг барьсан, үнэн эсэх нь батлагдаагүй өгөгдлийн багц нь нийгмийн тэгш бус байдлыг улам бүр нэмэгдүүлж, хүмүүсийг хуулийн өмнө харилцан тэгш байх эрхийг зөрчиж, **арьс өнгөөр ялгаварлан гадуурхагдсан бүлгүүд, эмэгтэйчүүд, нонбайнари** болон бусад бүлгүүдэд шударга бусаар нөлөөлж болзошгүй байна. Энэ нь **төрийн үйлчилгээнд хамрагдах, дур зоргоор баривчлахаас** ангид байх, **тэгш боломжоор хангагдах** зэрэг бусад эрхийг хэрэгжүүлэхэд нөлөөлдөг.

Интернэтээс устгагдсан хиймэл оюун ухаан хөгжүүлэлтэд ашиглагдаж байсан олон тооны мэдээллийн багц нь **эмэгтэйчүүдийг үзэн ядах, арьс өнгөөр ялгаварлан гадуурхах болон үндэстнийг гутаан доромжлох** үзэлтэй холбоотой мэдээллүүдийг агуулж байдаг: “Stable Diffusion” (текстэн дээр тулгуурлан зураг үүсгэдэг үүсгэгч хиймэл оюун ухаан) ашиглан бүтээсэн 5000 гаруй зурагт хийсэн Блүүмбэргийн **дүн шинжилгээнээс** харахад “арьс өнгөөр болон хүйсээр ялгаварлан гадуурхсан үзлийг” нэлээдгүй агуулсан болохыг нотолсон. Гүүглийн Бард үүсгэгч хиймэл оюун ухаантай чатбот) ижил хүйстнүүдийг эсрэг хүйстнээ сонирхдог болгохыг **зөвлөсөн** эмчилгээг санал болгож, Холокостыг хэзээ ч болоогүй гэж үгүйсгэж, хиймэл оюун ухаан гаргах нэрийн дор Еврейчүүдийн эсрэг антисемит үзлийг түгээсэн байна. Өөр нэг үүсгэгч хиймэл оюун ухаанд суурилсан **зураг бүтээх аппликейшн** хар арьст, ази, өнгөт арьст эмэгтэй хэрэглэгчдийн хүйсээр ялгаварласан, нүцгэн зургуудыг (ихэвчлэн тэдний арьсны өнгийг илүү цайвар болгож, биеийг нь туранхай болгож) гаргасан байна. Үүсгэгч хиймэл оюун ухаан нь хэвшмэл ойлголтыг улам дэвэргэж, тэдгээр нь ирээдүйн хиймэл оюун ухаан хөгжүүлэлтийн өгөгдөл болж байгаа нь нэг талыг баримталсан тогтсон хандлагыг нэмэгдүүлж, санаандгүйгээр сөрөг үр дагаврыг нийгэмд бий болгох эрсдэлтэй юм.

Эдгээр хиймэл оюун ухааны хэрэгсэлүүд нь шинэ контент бүтээх, **сэтгэл хөдлөлд дүн шинжилгээ хийх, эрүүл мэндийн онош тавих, ажил горилогчдыг шалгах,** бусад чухал шийдвэр гаргахад хэрэглэгддэг. Тиймээс компаниуд өөрсдийн ашиглаж буй эдгээр хэрэгслийг хүний эрхийн аливаа зөрчил гаргаж байгаа эсэх, уг зөрчлийг бий болоход хувь нэмэр оруулж байгаа эсэх эсхүл хүний эрхийн зөрчлийг дэмжиж байгаа эсэхэд мөн хэвшмэл ойлголтыг үргэлжлүүлэхгүй байхад хяналт тавих ёстой.

ҮҮСГЭГЧ ХИЙМЭЛ ОЮУН УХААН НЬ **ХЭВШМЭЛ ОЙЛГОЛТЫГ УЛАМ ДЭВЭРГЭЖ** ТЭДГЭЭР НЬ ИРЭЭДҮЙН ХИЙМЭЛ ОЮУН УХААН ХӨГЖҮҮЛЭЛТИЙН ӨГӨГДӨЛ БОЛЖ БАЙГАА НЬ **НЭГ ТАЛЫГ БАРИМТАЛСАН ТОГТСОН ХАНДЛАГЫГ НЭМЭГДҮҮЛЖ,** СӨРӨГ ҮР ДАГАВРЫГ НИЙГЭМД БИЙ БОЛГОХ ЭРСДЭЛТЭЙ.

ХУДАЛ, ТАШАА МЭДЭЭЛЛИЙГ АШИГЛАХ НЬ

Үүсгэгч хиймэл оюун ухааны хэрэглээнд худал болон ташаа мэдээллийг ашигласан, нэг талыг барьсан, **аюултай** контентыг бий болгосон, цахим сүлжээнд нөлөөлсөн, мэдээллийн экосистемийг хурдацтай бохирдуулсан олон жишээ байна. НҮБ-ын Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн дээд комиссарын хэлснээр, ташаа мэдээлэл нь “буруу мэдээлэл” байдаг бол худал мэдээлэл нь “хууран мэхлэлт, фишинг, суртал ухуулга зэрэг санаатайгаар хийсэн хор хөнөөл учруулах контент” гэж тодорхойлсон. НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Антонио Гутерришийн хэлснээр “Үүсгэгч хиймэл оюун ухаан нь худал мэдээлэл болон үзэн ядсан үг хэллэгийг тараахад нөлөөлөх боломжтой” гэж хэлжээ. Үүнтэй зэрэгцээд үүсгэгч хиймэл оюун ухааны хэрэгслүүдийг ашиглаж контентэд зохицуулалт хийх нь нэмэгдсээр байна. Контент зохицуулалт нь магадгүй хүмүүсийг хэт туйлширсан, түгшүүр төрүүлсэн контент үзэхээс сэргийлж болох ч, нөгөө талаасаа гадуурхагдсан, эрхээ хязгаарлуулсан хүмүүсийн дуу хоолойг хэт туйлширсан эсхүл улс төрийн ашиг сонирхолтой холбоотойгоор устгах нөхцөл байдлыг үүсгэж болзошгүй юм. Олон компани контентыг автоматаар устгах хэрэгслүүдийн гүйцэтгэх үүрэг эсвэл хуурамчаар устгагдсан контентыг хэрхэн зохих ёсоор буцаан гаргах талаар

мэдээллийн **ил тод байдлыг хангаагүй** хэвээр байна. Англиас бусад хэл дээрх хиймэл оюун ухааны загваруудад эрсдэл улам нэмэгдэж байдаг. Учир нь бусад хэл дээрх загварууд сул тал ихтэй бөгөөд бага төлөөлөл бүхий бүлгүүдэд хэрэглэгддэг хэл дээрх хүний эрхийн чиглэлээр бэлтгэгдсэн контент зохицуулагчдын тоо хангалтгүй байдаг.

Гэсэн хэдий ч үүсгэгч хиймэл оюун ухааны хэрэгслүүд улам боловсронгуй болж, хуурамч, гүтгэсэн эсвэл залилсан контентыг үйлдвэрлэх, түгээх нь нэмэгдэж, зорилтот нийгмийн бүлгүүдийг чиглүүлэхэд улам хялбархан болж, үүсгэгч хиймэл оюун ухааныг ашиглан бүтээсэн мэдээллүүд нь **урьдчилан таамагласан** итгэл үнэмшил, үнэт зүйлс дээр тулгуурлан бий болж үр дүн нь манипуляц хийн чиглүүлэх суурийг бүрдүүлж байна. Ялангуяа сонгуулийн үед уг эрсдэл улам бүр нэмэгдэж байна.

АНУ-д ялгаварлан гадуурхагдсан бүлгүүдэд санал өгөх өдөр болон байршлын талаар **буруу ташаа мэдээллийг** албаар цацаж байсан. Туркийн 2023 оны сонгуулийн үеэр генератив (үүсгэгч) хиймэл оюун ухааныг ашиглаж эсрэг талын нэр дэвшигчидтэй холбоотой **150 гаруй үндэслэлгүй мэдээлэл** цацсан ба нэг жишээ нь л гэхэд эсрэг талын нэр дэвшигчдийг “террорист” үйл ажиллагаатай холбоотой гэж буруутгасан

байсан. Харвардын их сургуулийн мэдээллийн өгөгдөл судлаачдын үзэж байгаагаар, үүсгэгч хиймэл оюун ухаан дээр суурилсан технологийн үр нөлөө нь бодлого боловсруулах тогтолцооны **хамгийн сул цэг рүү** чиглэдэг байж магадгүй гэжээ.

СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНД, БИЕ МАХБОДЫН БОЛОН АЛДАР ХҮНДЭД АЮУЛ УЧРУУЛАХ НЬ

Хиймэл оюуны тусламжтайгаар бүтээгдсэн контент дээр тулгуурлаж дуу хоолойг дуурайлгах, хуурамч бичлэг хийж сэтгэл зүйн хүчирхийлэл болон худал гүтгэлэг үйлдэх эсвэл дээр дурдсан зүйлсийг хослуулан зориудаар онилж, хүчирхийлэлд хэрхэн ашиглаж болохыг сүүлийн хэдэн жил харуулсан. Ижил төрлийн контент бүтээдэг шинэ төрлийн үүсгэгч хиймэл оюун ухааны хэрэгслүүдээс харахад энэ асуудал нь улам бүр дордох аюултай байна. Энэ нь дарамт шахалт, доромжлол, мөлжлөг, шантаачлах нөхцөлийг улам бүр нэмэгдүүлж, бие махбодын болон сэтгэцийн эрүүл мэндэд маш хортой нөлөө үзүүлэх боломжтой. Үүсгэгч хиймэл оюун ухааныг улс төрийн үзэлтэй санал нийлдэггүй бүлгүүд, сэтгүүлчид, хүний эрхийг хамгаалагчдын эсрэг дарангуйлах зэвсэг

**ТУРКИЙН 2023 ОНЫ СОНГУУЛИЙН ҮЕД
ҮҮСГЭГЧ ХИЙМЭЛ ОЮУН УХААНЫГ
150 ГАРУЙ ҮНДЭСЛЭЛГҮЙ МЭДЭЭЛЭЛ
ГАРГАХАД АШИГЛАСАН БОЛОХЫГ
ТОГТООСОН.**



болгон ашиглах боломжтой учир нийгэмд учирч болох эрсдэл улам нэмэгдэж байна. Хуурамчаар шантаачлах, гүтгэлэгт чиглэсэн контент идэвхитнүүдийг чимээгүй болгоход ашиглагдаж хүний эрхийг хамгаалах чадавхыг нь бууруулдаг. Түүнчлэн мэдээлэгч болон хүний эрхийн хамгаалагчдын нэр хүндийг олон нийтийн өмнө гутаан доромжлох замаар шийтгэл хүлээдэггүй байдлыг дэмжиж, хүмүүсийг нийгмийн аливаа хөдөлгөөнд оролцохоос сэргийлэх нөхцөл бий болгож байна. Үүсгэгч хиймэл оюун ухааны хэрэгслүүд улам дэвшилтэт болохын хэрээр гүтгэгдсэн хүмүүсийн гэм буруугүйг нотлох нь улам хэцүү болж, тухайн гүтгэсэн контент нь хуурамч гэдэг нь батлагдсан ч нийгэмд эсвэл хохирогчдод удаан хугацааны сөрөг нөлөө үзүүлэх боломжтой.

Компаниуд хүний эрхийг хангалттай хамгаалж чадаж байгаа гэдгээ хараахан нотолж амжаагүй байгаа энэ үед үүсгэгч хиймэл оюун ухааныг цэргийн болон батлан хамгаалахын технологид ашиглах нь амьд явах эрхэд ноцтой эрсдэл учруулж байна. Жишээлбэл, Пентагоны Батлан хамгаалахын дэвшилтэт технологийн судалгааны төслүүдийн агентлагийн хэвлэлийн төлөөлөгчийн хэлснээр үүсгэгч хиймэл оюун ухааны систем нь үхэл, амьдралтай холбоотой чухал шийдвэр гаргахад хэрэглэгдэх, итгэж болохуйц хэмжээний түвшинд хүрсэн эсэх тухай ноцтой асуудлыг хөндсөн. Мөргөлдөөний үед үүсгэгч хиймэл оюун ухааныг энгийн иргэд, дүрвэгсдийн эсрэг “нэмэлт хүч” болгон ашиглах эрсдэлтэй бөгөөд цаашлаад тухайн хиймэл оюун ухаан алдаа гаргах, зөвшөөрөлгүй ашиглагдах эсвэл хакердуулах зэргээр засаж болшгүй үр дагаварт хүрч, хариуцлагын асуудал хөндөгдөж болзошгүй байна.

ҮҮСГЭГЧ ХИЙМЭЛ ОЮУН УХААНЫ СИСТЕМ НЬ ҮХЭЛ, АМЬДРАЛТАЙ ХОЛБООТОЙ ЧУХАЛ ШИЙДВЭР ГАРГАХАД ХЭРЭГЛЭГДЭХ, ИТГЭЖ БОЛОХУЙЦ ХЭМЖЭЭНИЙ ТҮВШИНД ХҮРСЭН ЭСЭХ ТУХАЙ НОЦТОЙ АСУУДЛЫГ БИЙ БОЛГОЖ БАЙНА.

ХИЙМЭЛ ОЮУН УХААН ОДОО БАЙГАА БҮХ АЖЛЫН БАЙРНЫ 1/4-ИЙГ АВТОМАТЖУУЛЖ ЧАДНА ГЭСЭН МЭДЭЭЛЭЛ БАЙНА.



ХӨДӨЛМӨРЛӨХ ЭРХИЙГ ЗӨРЧИХ НЬ

Цалингүй уран бүтээлчид болон хөдөлмөрийн мөлжлөгөд өртсөн бага цалинтай ажилчдад түшиглэсэн үүсгэгч хиймэл оюун ухаан хөгжүүлэгч компаниуд нь энэхүү технологийн хамгийн гол санхүүгийн ашиг хүртэгчид бөгөөд эрх мэдэл, санхүүгийн тэгш бус байдлыг нэмэгдүүлж байна.

Үүсгэгч хиймэл оюун ухаан нь одоогийн байгаа бүх ажлын байрны дөрөвний нэгийг автоматжуулж, 300 сая ажлын байранд нөлөөлөх боломжтой гэсэн мэдээлэл байна. Ажилчдыг дэмжиж, даалгавар, үр бүтээмжийг нь нэмэгдүүлэхийн оронд шинэ технологиор дамжуулж ажлыг автоматжуулах нь дэлхийн нийлүүлэлтийн сүлжээн дэх орлогын тэгш бус байдал, одоо байгаа эрчим хүчний тэнцвэргүй байдлыг улам хурцатгах магадлалтай юм. Үүсгэгч хиймэл оюун ухааны шинэ ажлын байр бий болгох боломжийг судлахаас урьтаж хамгийн эмзэг бүлгийнхэнд энэхүү эдийн засгийн хямрал хэр зэрэг мэдрэгдэж байгааг болон түүнээс гарах зардлыг тооцоолох шаардлагатай.

300 САЯ
АЖЛЫН
БАЙР


ГЕНЕРАТИВ (ҮҮСГЭГЧ)
ХИЙМЭЛ ОЮУНЫ
НӨЛӨӨНД ӨРТСӨН ГЭХ
МЭДЭЭ БАЙНА



ВЕНЧУР КАПИТАЛ ФИРМУУД ХҮНИЙ ЭРХИЙН МАГАДЛАН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ АЧ ХОЛБОГДОЛ

Венчур капитал (VC) фирмүүд (хувийн капитал сангуудын экосистемийн оролцогчдын нэг) нь эхэн болон өсөлтийн шатандаа байгаа компаниудыг (ихэвчлэн «гарааны бизнесүүд» гэж нэрлэгддэг) өөрийн хөрөнгөөр санхүүжүүлдэг тул ихэнхдээ тухайн компаниудын засаглал, үйл ажиллагаанд нөлөөлөх боломжтой байдаг.

2021 ОНД СУДАЛГААНД ХАМРАГДСАН 53 ФИРМИЙН 1 НЬ Л НҮБ-ЫН УДИРДАХ ЗАРЧМУУДЫГ ХАНГАСАН ХҮНИЙ ЭРХИЙН МАГАДЛАН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ЖУРАМТАЙ БАЙСАН.



ВЕНЧУР КАПИТАЛ ФИРМУУД ХҮНИЙ ЭРХИЙН МАГАДЛАН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ АЧ ХОЛБОГДОЛ

Эмнести Интернэшнл **“Эрсдэлтэй Бизнес”** **тайланг** 2021 онд нийтэлсэн. Уг тайланд тэргүүлэгч венчур капиталын фирмүүд **технологид хөрөнгө оруулахдаа хүний эрхийн магадлан шинжилгээ** хийхгүй байгаа нь тогтоогдсон. Эмнести Интернэшнл дэлхийн хамгийн том венчур капитал фирмүүд болон гарааны бизнесийн хурдасгуур 53 компанид судалгаа явуулахад НҮБ-ын удирдах зарчмуудад тусгагдсан стандартыг хангасан хүний эрхийн магадлан шинжилгээ хийж буй нэг л компани байсан. Бусад судалгаанд хамрагдсан компаний 98 гаруй хувь нь буюу 52 фирм болон хурдасгуур нь НҮБ-ын удирдах зарчмуудын стандартад нийцсэн хүний эрхийн магадлан шинжилгээ хийж гүйцэтгээгүй байна. Эмнести Интернэшнл судалгаанд хамрагдсан 44 фирм буюу нийт компаний 83% нь хүний эрхийн магадлан шинжилгээ хийсэн эсэх талаар ямар нэгэн баримт олоогүй.

2022 онд венчур капитал фирмүүдийн үүсгэгч хиймэл оюун ухаанд оруулсан хөрөнгө оруулалт 2.1 тэрбум ам.долларт хүрсэн нь 2020 онтой харьцуулахад 425%-иар өссөн үзүүлэлт юм. Тэргүүлэгч венчур капитал фирм, хурдасгуурууд,

Майкрософт, Гүүгл зэрэг томоохон технологийн компаниудтай адил үүсгэгч хиймэл оюун ухааныг хурдан хөгжүүлэхэд ихээхэн хөрөнгө оруулалт хийж байна. Жишээлбэл, Инсаят Партнерс нь Жаспер гэх текстэд суурилсан хиймэл оюун ухааны программд хөрөнгө оруулалт хийж байгаа бөгөөд “Инсаят Партнерс нь хиймэл оюун ухааны хүртээмжтэй байдлыг тодорхойлохын тулд энэхүү программыг хөгжүүлэхэд 125 сая долларын хөрөнгө оруулалт хийгээд байна”. Лайятспийд Венчур Партнерс нь Стабл Диффузиний (текст өгөгдөлд үндэслэн зураг үүсгэдэг үүсгэгч хиймэл оюун ухааны загвар) Стабилити хиймэл оюун ухаанд хөрөнгө оруулалт хийсэн. Сэкуоа Капитал нь үүсгэгч хиймэл оюун ухааны компаниуд болох ДАЛЛ-И (OpenAI 2021 онд худалдаж авсан) болон Антропикд хөрөнгө оруулалт хийсэн ба энэ хиймэл оюун ухаан нь сошиал медиагаас тоглоом бүтээх, зар сурталчилгаанаас архитектур, код бичихээс график дизайн, бүтээгдэхүүний дизайнаас хууль, маркетингаас худалдан авалт хүртэл бүх салбарт нөлөөлнө гэсэн итгэлтэйгээр хөрөнгө оруулалт хийсэн.

ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ 2021 ОНД
СУДАЛГААНД ХАМРАГДСАН ФИРМҮҮДИЙН
44 НЬ БУЮУ НИЙТ КОМПАНИЙН 83% НЬ
ХҮНИЙ ЭРХИЙН МАГАДЛАН ШИНЖИЛГЭЭ
ХИЙСЭН ЭСЭХ ТАЛААР ЯМАР НЭГЭН
БАРИМТ ОЛООГҮЙ.

НҮБ-ын Бизнес ба Хүний Эрхийн удирдах зарчмуудын дагуу компаниуд хүний эрхийг хүндэтгэх хариуцлага хүлээсэн. Компаниудын хүний эрхийг хүндэтгэх хариуцлага нь тэдний өөрсдийн бизнесийн үйл ажиллагаагаар дамжуулан хүний эрхийн зөрчил гаргах эсхүл хувь нэмэр оруулахаас зайлсхийх мөн бодит нөлөөллийг багасгахыг шаарддаг. Түүнчлэн хэдийгээр тухайн зөрчил бий болоход аж ахуйн нэгжүүд хувь нэмэр оруулаагүй ч өөрсдийн үйл ажиллагааболон бизнесийн түншийн бүтээгдэхүүн, үйлчилгээтэй шууд холбоотойгоор үүссэн хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, үр нөлөөллийг багасгахыг шаарддаг. Санхүүгийн салбарт хөрөнгө оруулагч болон хөрөнгийг хүлээн авч буй компаниуд, тэдгээрийн жижиг хувьцаа эзэмшигчийн хоорондын харилцааг “бизнесийн харилцаа” гэж үзэж болно.

Технологийн салбарт хөрөнгө оруулалт хийж буй хөрөнгө оруулагчдад НҮБ-ын удирдах зарчмууд хэрхэн хэрэглэгдэж болох тухай дурдсан олон тооны эх сурвалжууд байдаг. Үүнд, бизнесийн загвартай холбоотой эрсдэлийг шийдвэрлэх замаар хэрэгжүүлэх, эцсийн хэрэглээтэй холбоотойгоор бий болсон хүний эрхийн эрсдлийг тодорхойлох, үр дүнтэй зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх механизмыг бий болгон хэрэгжүүлж, хүртээмжтэй болгох, мөн ороцлогч талуудын оролцоог сайжруулах зэрэг багтаж байна.

Хөрөнгө оруулагч болон хөрөнгө оруулалтыг хүлээн авч буй компаниудын аль аль нь хиймэл оюун ухааны сайн тал болон үүсгэж болзошгүй хүний эрхийн бодит нөлөөллийг тодорхойлж, хариу арга хэмжээ авах идэвхтэй, байнгын алхмуудыг хийх ёстой. Энэ нь хүний эрхэд үзүүлж буй нөлөөллийг тодорхойлох, урьдчилан сэргийлэх, бууруулахын тулд хүний эрхийн магадлан шинжилгээ хийх мөн тухайн хүний эрхийн нөлөөллийг хэрхэн шийдвэрлэх талаарх арга барилыг тодорхойлох зэрэг багтана. Хүний эрхийн магадлан шинжилгээнд хүний эрхэд учирсан болон учирч болзошгүй нөлөөллийг үнэлэх мөн тухайн үнэлгээнд тулгуурлан авах арга хэмжээг тодорхойлж, хэрэгжүүлэх үйл явцыг багтаан ойлгоно.

Венчур капитал фирмүүдийн хувьд энэхүү үүрэг хариуцлага нь ямар салбарт анхаарлаа хандуулах, аль компанид хөрөнгө оруулахаа сонгох, хүний эрхийг дээдэлсэн гарааны бизнесийн хөгжилд нөлөөлөх хөшүүрэг болно.

ҮР ДҮНТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙН МАГАДЛАН ШИНЖИЛГЭЭ ХИЙХИЙН ТҮЛД ВЕНЧУР КАПИТАЛ (VC) ФИРМУУД ДАРААХ ЗҮЙЛСИЙГ ХИЙХ ЁСТОЙ:

ӨӨРИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААТАЙ
ХОЛБООТОЙ ҮҮСЧ
БУЙ ХҮНИЙ ЭРХИЙН
СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ
ШИЙДВЭРЛЭХИЙН ТҮЛД
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ АВСАН
КОМПАНИУД,

ХҮНИЙ ЭРХЭД СУУРИЛСАН
ВЕНЧУР КАПИТАЛ (VC)
СҮЛЖЭЭ БОЛОН ЭВСЛҮҮД,
МӨН ИРГЭНИЙ НИЙГМИЙН
БАЙГУУЛЛАГУУД ЗЭРЭГ
БУСАД ОРОЛЦОГЧ
ТАЛУУДТАЙ ХАМТРАН
АЖИЛЛАХ.

ӨӨРСДИЙН ХҮНИЙ
ЭРХИЙН МАГАДЛАН
ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ҮЙЛ
ЯВЦ БОЛОН ХҮНИЙ ЭРХТЭЙ
ХОЛБООТОЙ ЭРСДЭЛ,
СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ
ШИЙДВЭРЛЭХЭД АВЧ БУЙ
АРГА ХЭМЖЭЭГ ИЛ ТОД
БОЛГОХ.

ХҮНИЙ ЭРХИЙН
ЭРСДЭЛ, НӨЛӨӨЛЛИЙГ
ТОДОРХОЙЛЖ ТЭДГЭЭРИЙГ
БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ
АВАХ.

ШИНЭЭР БИЙ БОЛЖ БУЙ
САЙН ТУРШЛАГА, ЭРСДЭЛ
МӨН ӨӨРЧЛӨГДӨЖ БУЙ
НӨХЦӨЛ БАЙДАЛД ДАСАН
ЗОХИЦОХ ЗОРИЛГООР

КОМПАНИЙ ХИЙЖ БУЙ
ХҮНИЙ ЭРХИЙН МАГАДЛАН
ШИНЖИЛГЭЭНИЙ ҮЙЛ
ЯВЦЫГ БАЙНГА ҮНЭЛЖ,
САЙЖРУУЛАХ

Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа,
Хөгжлийн Байгууллагаас (OECD)
шинэчлэн гаргасан **“Үндэстэн
Дамнасан Корпорациудад зориулсан
Хариуцлагатай Бизнесийн Үйл
Ажиллагааны Удирдамж”**-д зааснаар
технологийн хөгжүүлэлт, санхүүжилт,
худалдан борлуулалт, лиценз олголт, мөн
мэдээлэл цуглуулах, ашиглахад магадлан
шинжилгээ хийхийг шаарддаг болсоноос
гадна компанийн бүтээгдэхүүн, үйлчилгээг
хэрэглэхтэй холбоотой бизнесийн түншийн
харилцааны улмаас бий болсон нөлөөлөлд
хүний эрхийн болон байгаль орчны
магадлан шинжилгээ хийх шаардлагатай
болж байна. Энэ нь хөрөнгө оруулалтын
эхэн үеэс бүтээгдэхүүн эцсийн хэрэглэгчдэд
хүрэх хүртэлх технологийн салбарын
нэмүү өртгийн сүлжээний бүхий л үе
шатад компаний хариуцлагыг нэмэгдүүлэх
шаардлагатайг харуулж байна. Оролцогч

талуудтай үр дүнтэйгээр хамтран ажиллах нь
бизнесийн үйл ажиллагаанд өртөж, үүний
улмаас эрсдэлд орох боломжтой хүмүүсийг
зүй зохистойгоор анхаарч, хамгаалахад
нэн шаардлагатай учир энэ нь магадлан
шинжилгээний үйл явцад чухал байр
суурийг эзэлдэг. Венчур капитал фирмүүд
нөлөөлөлд өртсөн бүлгүүдийн оролцоог
нэмэгдүүлж, хамтран ажиллахад шууд үүрэг
гүйцэтгэхээс гадна өөрсдийн хөрөнгө оруулж
буй технологийн компаниуд болон эрсдэлт
бүлгүүдийн хоорондын үр дүнтэй хамтын
ажиллагааг нэмэгдүүлэхэд хувь нэмэр
оруулах ёстой.

2023 оны 8-р сарын 23-нд АНУ-ын Үнэт цаас, биржийн хороо (SEC) хувийн капитал сангуудын ил тод, шударга, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн шинэ дүрмийг баталсан. венчур капитал фирмүүд итгэлцлийн үүргээ биелүүлж, тэтгэврийн хуримтлалд хөрөнгө оруулалт хийсэн хувь хүмүүс болон бусад хөрөнгө оруулагчдын ашиг сонирхлыг хамгаалахын тулд цаашид нягт нямбай байх ёстой. Томоохон венчур капитал (VC) фирмүүдийн дийлэнх нь АНУ-д байрладаг ба тэд энэхүү шинэ дүрмийг дагаж мөрдөх үүрэгтэй. Түүнчлэн SEC-ийн үзэж буйгаар хувийн сангийн зөвлөхүүд шинэ хуулийн дагуу тусгайлан зохицуулаагүй байсан ч одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн дагуу болгоомжгүй, хайнга байдлын улмаас хохирол учруулсан тохиолдолд хариуцлагаас чөлөөлөгдөх боломжгүй.

Венчур капитал фирмүүд хувьд хүний эрхийн магадлан шинжилгээ хийх нь НҮБ-ын удирдах зарчмуудад заасан олон улсын хүний эрхийн, үндэсний болон бүс нутгийн комплаенсийн стандартуудад тусгагдсан үүрэг хариуцлагыг биелүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ. Үнэт цаас, биржийн хорооны шинэ дүрэм нь хөрөнгө оруулалтын эрсдэл, зохих шалгалт, засаглалын механизм, мөн магадлан шинжилгээ хийх үйл явцыг хувийн капитал сангууд хэрхэн удирдан явуулах тал дээр АНУ-ын хууль тогтоогчдын харах өнцөгт

өөрчлөлт оруулах зорилготой байсан. Үүнтэй адилаар хүний эрхийн магадлан шинжилгээ нь Европын Холбооны Компаний Тогтвортой Байдлын талаарх Магадлан Шинжилгээ Хийх Удирдамжийн гол зорилго байсан бөгөөд энэ нь Европын Холбооны хууль тогтоогчдын нэн тэргүүлэх чиглэлд өөрчлөлт оруулсан үйл явдал болсон юм.

ВЕНЧУР КАПИТАЛ ФИРМУУДИЙН ХУВЬД ХҮНИЙ ЭРХИЙН МАГАДЛАН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ НЬ ОЛОН УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ХЭМ ХЭМЖЭЭНД ЗААСАН ҮҮРГЭЭ БИЕЛҮҮЭХЭД ЧУХАЛ ҮҮРЭГТЭЙ.

**2023.08.23-НД, АНУ-ЫН ҮНЭТ ЦААС,
БИРЖИЙН ХОРОО (SEC) ХУВИЙН
КАПИТАЛ САНГУУДЫН ИЛ ТОД,
ШУДАРГА, ХАРИУЦЛАГАТАЙ БАЙДЛЫГ
НЭМЭГДҮҮЛЭХЭД ЧИГЛЭСЭН ШИНЭ
ДҮРМИЙГ БАТАЛСАН.**





ҮР ДҮНГИЙН ХУРААНГУЙ

Венчур капитал фирмүүд өөрсдийн хүний эрхэд учруулж байгаа нөлөөллийг тодорхойлж, урьдчилан сэргийлж, бууруулахын тулд хийж буй хүний эрхийн магадлан шинжилгээний түвшинг үнэлэхийн тулд АНУ-ын Эмнести Интернэшнл, Бизнес ба Хүний Эрхийн Мэдээллийн Төв нь дор хаяж 1 үүсгэгч хиймэл оюун ухааны хөрөнгө оруулалт хийсэн 10 том венчур капитал (VC) сан болон 2 хурдасгуурын хүний эрхийн бодлогыг судалсан. Бид венчур капитал сэтгүүлийн 2022 оны венчур капитал (VC)-ын жагсаалтыг ашиглан менежментийн хөрөнгөөрөө хамгийн том 50 венчур капитал (VC) фирмийг тодорхойлж, дараа нь Dealroom-ийн өгөгдлийг ашиглаж аль нь генератив хиймэл оюун ухаан хөгжүүлж буй компанид хөрөнгө оруулалт хийсэн болохыг тодорхойлсон.

ҮР ДҮНГИЙН ХУРААНГУЙ

Энэхүү аргачлалын хүрээнд хамгийн багадаа нэг үүсгэгч хиймэл оюун ухаан хөгжүүлэхэд хөрөнгө оруулсан 10 Венчур Капитал фирмийг тодорхойлсон бөгөөд эдгээр нь: Инсаят Партнерс, Таягар Глобал Менежмент, Сикуоиа Капитал, Андреессен Хоровиц, Лаятспид Венчур Партнерс, Нью Энтерпрайс Ассосиатес, Бэссэмер Венчур Партнерс, Женерал Каталист Партнерс, Фоундерс Фанд болон Технологи Кросвер Венчурс болно. Энэхүү аргачлалын хүрээнд хамгийн багадаа нэг үүсгэгч хиймэл оюун ухаан хөгжүүлж

буй компанид хөрөнгө оруулсан 2 гарааны бизнесийн хурдасгуурыг тодорхойлсон бөгөөд тэдгээр нь Текстарс болон Вая Комбинатор юм.

Сонгогдсон венчур капитал (VC) фирмүүд болон хурдасгуурууд аль түвшинд хүний эрхийн магадлан шинжилгээ хийж байгааг үнэлэхийн тулд АНУ-ын Эмнести Интернэшнл, Бизнес ба Хүний Эрхийн МэдээллийнТөв дараах 4 шалгуурыг авч үзсэн.

1. АМЛАЛТ

ТУХАЙН КОМПАНИ ЦАХИМ ХУУДСАН ДЭЭРЭЭ ОЛОН НИЙТИЙН СҮЛЖЭЭГЭЭР ДАМЖУУЛЖ ТЕХНОЛОГИЙН САЛБАРТ ХАРИУЦЛАГАТАЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ АМЛАЛТ ӨГСӨН ҮҮ? ТУХАЙН АМЛАЛТАД ХҮНИЙ ЭРХИЙН ТАЛААР ИЛТ ТУСГАСАН УУ?

3. МАГАДЛАН ШИНЖИЛГЭЭ

ТУХАЙН КОМПАНИ ТЕХНОЛОГИД ХӨРӨНГӨ ОРУУЛАХ ШИЙДВЭР ГАРГАХДАА НИЙГЭМ, БАЙГАЛЬ ОРЧИНД ХЭРХЭН НӨЛӨӨЛЖ БУЙ ГЭДГИЙГ ТУСГАЙЛАН АНХААРДАГ ТУХАЙ ОЛОН НИЙТЭД МЭДЭЭЛЛЭСЭН ҮҮ?

МАГАДЛАН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮЙЛ ЯВЦЫН НЭГ ХЭСЭГ БОЛГОН ХҮНИЙ ЭРХИЙН МАГАДЛАН ШИНЖИЛГЭЭ ХИЙЖ ГҮЙЦЭТГЭДЭГ ГЭДГИЙГ ТУСГАЙЛАН МЭДЭЭЛЛЭСЭН ҮҮ?

2. БОДЛОГО

ТУХАЙН КОМПАНИ АЛБАН ЁСНЫ ХАРИУЦЛАГАТАЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГЫГ ОЛОН НИЙТЭД ЗОРИУЛЖ НИЙТЭЛСЭН ҮҮ?

ТУХАЙН БОДЛОГОД ХҮНИЙ ЭРХИЙН ТАЛААР ИЛТ ТУСГАСАН УУ?

4. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХҮЛЭЭН АВЧ БУЙ КОМПАНИУДАД ҮЗҮҮЛЖ БУЙ ДЭМЖЛЭГ

ХӨРӨНГӨ ОРУУЛСНЫ ДАРАА ТУХАЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ХҮЛЭЭН АВСАН КОМПАНИУДАД ХАРИУЦЛАГАТАЙ ТЕХНОЛОГИТОЙ ХОЛБООТОЙ АСУУДЛЫГ ХЭРХЭН ШИЙДВЭРЛЭН САЙЖРУУЛАХ ТАЛ ДЭЭР ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛДЭГ ҮҮ?

ТУХАЙН КОМПАНИ НЬ ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ЯВЦДАА ХҮНИЙ ЭРХТЭЙ ХОЛБООТОЙ СТАНДАРТУУДЫГ МӨРДӨХ ТАЛААР ТУСГАЙЛАН ДУРДДАГ УУ?

Энэхүү судалгааны үр дүнд тэргүүлэгч венчур капитал (VC) фирм, хурдасгуурууд үүсгэгч хиймэл оюун ухааны гарааны бизнест хөрөнгө оруулахдаа хүний эрхийн магадлан шинжилгээ хийх үүргээ хангалтгүй биелүүлж байгааг харуулсан. Харамсалтай нь тус дүгнэлт нь Эмнести Интернэшнлийн 2021 оны “Эрсдэлтэй Бизнес” тайлангийн үр дүнтэй адилхан байгаа бөгөөд энэ нь НҮБ-ын удирдах зарчмуудыг хангахын тулд хүний эрхийн магадлан шинжилгээ хийх үүргийн биелэлт сүүлийн хоёр жилийн хугацаанд ахиц маш багатай байгааг харуулж байна.

12 фирмийн гурав нь л (Инсаят Партнерс, Женерал Каталист Партнерс, Текстарс) хөрөнгө оруулалт хийхдээ хариуцлагатай технологийн ойлголтыг анхаарч үзэх амлалт өгсөн. Зөвхөн нэг фирм (Текстарс) хүний эрхийг амлалтынхаа нэг хэсэг болгон дурьдсан ч “Женерал Каталист” компани нь “нууцлал”, “ил тод байдал” ба “хариуцлага” гэх мэтчилэн дижитал эрхтэй холбоотой зарим ойлголтыг дурдсан байна.

12 фирмийн зөвхөн нэг нь (Текстарс) олон нийтэд нээлттэй хариуцлагатай хөрөнгө оруулалтын бодлоготой. “Текстарс”-ын бодлого, тэр дундаа ажилчид болон компанийг үүсгэн байгуулагчдын ёс зүйн дүрэмд хүний эрхийн талаар хэд хэдэн удаа дурьдсан. 2023 оны 11-р сард “Инсаят Партнерс” болон “Женерал Каталист” нь “Хариуцлагатай инновацын лаборатори”-оос боловсруулсан хариуцлагатай хиймэл оюун ухаан хөгжүүлэх амлалтад гарын үсэг зурж, фирмүүдэд “хариуцлагатай хиймэл оюун ухааны практикийг бий болгох, нэвтрүүлэх” үүрэг хүлээсэн юм.

12 фирмийн зөвхөн нэг нь (Текстарс) хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл (LPS) сонгох болон компанид хөрөнгө оруулахдаа хүний эрхтэй холбоотой асуудлуудад магадлан шинжилгээ хийдэг тухай мэдэгдсэн. “Текстарс” хэлэхдээ,

НҮБ-ын удирдах зарчмуудыг хөрөнгө оруулалт авах хүсэлт гаргах үйл явцын нэг хэсэг болгон нэвтрүүлэхээр төлөвлөж байгаа гэж мэдэгдсэн ч, үүнийг хийсэн эсэх нь тодорхойгүй байна. Хоёр компани нь (“Инсаят Партнерс” болон “Женерал Каталист”) олон нийтэд учирч болох эрсдэл, түүний дотор хэвшмэл ойлголт, ялгаварлан гадуурхалтад чиглэсэн магадлан шинжилгээ хийх үйл явцыг хэрэгжүүлэх шатандаа явж байгаа гэж мэдэгдсэн. “Инсаят Партнерс” нь хүний эрхтэй холбоотой асуудлыг магадлан шинжилгээний нэг хэсэг болгосон тухай илт дурдаагүй боловч Европын Холбооны Мэдээлэл Хамгаалах Дүрэм Калифорни мужийн Хэрэглэгчийн Мэдээллийн акт мөн Виржиниа мужийн Хэрэглэгчийн Мэдээллийг Хамгаалах тухай акт зэрэг хууль тогтоомжуудаас урган гарсан мэдээллийн нууцлалтай холбоотой асуудлуудтай хамааран хөрөнгө оруулалт авч буй компаниудад эрх зүйн дүн шинжилгээ хийхэд анхаарал хандуулдаг байна.

Одоогоор 12 фирмийн зөвхөн нэг нь (“Инсаят Партнерс”) өөрийн хөрөнгө оруулсан компаниуддаа хариуцлагатай технологийн асуудлаар дэмжлэг үзүүлж байгаа ч, хүний эрхийн дүн шинжилгээ хийдэг эсэх талаар тусгайлан дурдаагүй байна. Хоёр фирм (“Женерал Каталист” болон “Текстарс”) нь хөрөнгө оруулсан компаниуддаа дэмжлэг үзүүлэх шатандаа явж байгаагаа олон нийтэд мэдэгдсэн. “Женерал Каталист” болон “Инсаят Партнерс” нь “Хариуцлагатай инновацын лаборатори”-оос боловсруулсан Хариуцлагатай хиймэл оюун ухаан хөгжүүлэх амлалтад гарын үсэг зурсан. Эдгээр компани нь (1) портфолио компаниудыг эдгээр сайн дурын амлалтуудыг хэрэгжүүлэхэд нь дэмжих, (2) эдгээр сайн дурын амлалтыг хиймэл оюун ухааны гарааны бизнест хөрөнгө оруулахад хийгдэх дүн

шинжилгээнд дурдах, (3) хөрөнгө оруулалт авсан компаниудын дунд хариуцлагатай хиймэл оюун ухааны дадлыг хөгжүүлэ."-ийг зорих амлалтыг өгсөн байна.

“Текстарс” нь үүсгэн байгуулагчидтай семинар зохион байгуулах замаар дэмжлэг үзүүлдэг бөгөөд ирээдүйд компаниудад үзүүлэх Байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-той холбоотой дэмжлэгийг нэмэгдүүлэхээр төлөвлөж байгаагаа мэдэгдсэн.

Технологийн бүтээгдэхүүн, гарааны бизнесийн загвар боловсруулах явцад хүний эрхийн магадлан шинжилгээ хийхгүй байгаа нь хүний эрхийн эрсдэлийн түвшинг нэмэгдүүлж байгаа бөгөөд энэхүү судалгааны үр дүнд венчур капитал фирм, хурдасгуурууд хүний эрхийн магадлан шинжилгээ хийх тухай нухацтай бодон, авч үзэн шийдвэрлэсэн байдал маш бага байна.

ТЭРГҮҮЛЭГЧ ВЕНЧУР КАПИТАЛ ФИРМУУДИЙН ХАРИУЦЛАГАТАЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТҮРШЛАГЫН ХУРААНГУЙ

ШИЛДЭГ 10 ВЕНЧУР КАПИТАЛ ФИРМ

FIRM	HEADQUARTERS	5-YR AUM (\$USD) ⁹⁷	# GENERATIVE AI INVESTMENTS (AS OF MAY 2023) ⁷⁸	COMMITMENT POLICY D	UE DILIGENCE	PORTFOLIO SUPPORT	SCORECARD (OUT OF 16)
Andreessen Horowitz	Menlo Park	20.81	1				0
Bessemer Venture Partners	Redwood City	9.523					0
Founders Fund	San Francisco	8.575					0
General Catalyst Partners	Cambridge	8.92	5	31	11		6
Insight Partners	New York	38.76		21	32		8
Lightspeed Venture Partners	Menlo Park	15	9				0
New Enterprise Partners	Chevy Chase	10	4				0
Sequoia Capital	Menlo Park	24.5	12				0
Technology Crossover Ventures	Menlo Park	7.68	1				0
Tiger Global Management	New York	26.86					0
ACCELERATORS							
Techstars	Boulder	1.1	04	43		1	12
Y Combinator	Mountain View	1.3	7				0



НИЙТ ҮНЭЛГЭ

Үнэлгээний хуудас:
2 - Хэрэгжүүлдэг
1 - Хэсэгчлэн хэрэгжиж байгаа эсвэл хэрэгжих шатандаа явж байгаа
0 - Олон нийтэд мэдээлсэн эх сурвалжаас харахад хэрэгжилт явагдаагүй бөгөөд, хэрэгжилтийн тухай тодруулсан захидалд хариу ирүүлээгүй.



ДҮГНЭЛТ

Үүсгэгч хиймэл оюун ухаан нийгэм, эдийн засаг, улс төрийг бүхлээр нь өөрчлөх боломжтой. Европын Комиссын Дижитал эрин үе дэх Европын Холбооны бодлого хариуцсан дэд ерөнхийлөгч Маргрете Вестагер хэлэхдээ “үүсгэгч хиймэл оюун ухаан бол тоглоомыг бүхлээр нь өөрчлөгч юм. Хиймэл оюун ухаан бол дараагийн хүчирхэг зүйл гэдгийг бид бүгд мэднэ.” Байдены засгийн газраас **боловсруулсан найдвартай, аюулгүй, итгэл даах хиймэл оюун ухааныг** баталгаажуулах амлалтад технологийн тэргүүлэгч 15 компани гарын үсэг зурсан ба үүнд хиймэл оюун ухааныг “Асар их нөөц бололцоо мөн асар их эрсдэлийг бий болгох боломжтой” гэж тодорхойлсон байдаг. Эрсдэлээр дүүрэн энэхүү технологид хөрөнгө оруулалт хийж буй нөөц бололцоо ихтэй тэргүүлэгч венчур капитал (VC) фирмүүд болон хурдасгуурууд генератив (үүсгэгч) хиймэл оюун ухаанаас үүдэлтэй хүний эрхийн эрсдэлийн талаар ямар ч хариу арга хэмжээ авахгүй чимээгүй байсаар байна. Венчур капиталистууд хүний эрхийг хамгаалах үүрэг хариуцлагаа ухамсарлаж, зүй зохистой хүний эрхийн магадлан шинжилгээ хийж хэрэгжүүлэх цаг болжээ.

Гуравдагч этгээд хүний эрхийн зөрчил гаргахаас сэргийлэх нь улс орнуудын олон улсын хүний эрхийн эрх зүйн дагуу хүлээсэн заавал биелэгдэх шинжтэй үүрэг юм. Энэхүү үүрэг нь тухайн улсын болон өөр улсын нутаг дэвсгэрт хүний эрхийн зөрчил гаргах мөн зөрчил бий болоход хувь нэмэр оруулахаас сэргийлэх зорилгоор өөрийн

нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй эсхүл өөрийн бүрэн хяналтад байгаа венчур капитал фирмүүд болон бусад компани үйл ажиллагааг зохицуулахыг ойлгоно.

Улс орнууд болон хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлүүд нь венчур капитал (VC) фирм, хурдасгууруудын зан үйл, харах өнцгийг өөрчлөхөд чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд үүний тулд ил тод байдлыг нэмэгдүүлэх нь хамгийн эхний алхам юм. Хувийн капитал сангууд болон иргэний нийгмийн хооронд мэдээллийн зөрүү их байгаа бөгөөд энэхүү судалгаанд венчур капитал (VC) фирм, хурдасгууруудын оролцоо дутмаг байгаа учир тус зөрүүг нөхөхийн тулд иргэний нийгмийн байгууллагуудад дэмжлэг шаардлагатай байна.

